



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/122

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6 дугаар зүйлийн “а”, “ж”, “л”, 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11.2, 11.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу тус аймаг нь халдварын тархалтын түвшингөөр “Ногоон түвшин”-д хамаарсан тул хязгаарлалтад орж үйл ажиллагаа нь хаагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс нээсүгэй.

2. Үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын 2 дугаар бүлэгт заасан “Бэлтгэл ажлын үед авах арга хэмжээ”-г холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвлөмж, чиглэл авсны үндсэн дээр бүрэн хэрэгжүүлж, цаашид түр журмыг мөрдлөг болгон ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эхлэхийн өмнөх халдвар хамгааллын дэглэм болоод бусад зохион байгуулалтын арга хэмжээний бэлтгэл ажлын явц, гүйцэтгэл, үйл ажиллагаа эхэлсний дараах халдвар хамгааллын ажилд тогтмол хяналт шалгалт хийж, 18 дугаар тушаалаар баталсан түр журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаа нь нээсэн аж ахуйн нэгж, байгууллагын иргэдэд үйлчлэх цагийн хуваарь, хугацаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Ганзориг), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Аймгийн хэмжээнд халдварын голомттой бүс нутгаас ирэх иргэдийн хөдөлгөөн ихсэх эрсдэл өндөр байгаа тул сум орон нутагтаа хөдөлгөөнт болон байнгын ажиллагаатай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг чангатгаж, гэрийн ажиглалтыг 14 хоног байлган хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Цагдаагийн газар (Б.Ганзориг), бүх шатны Засаг дарга дарга нарт үүрэг болгосугай.

6. 2020 онд иргэн аж ахуйн нэгж байгууллагаас цугларсан хандивын хөрөнгөөс 6,185,280 төгрөгийг зохих журмын дагуу Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн

дансруу шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д даалгасугай.

7. Аймгийн Шуурхай штабын бичиг хэрэг, шатахууны зардал болон бусад шаардлагатай зардалд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас гарган санхүүжүүлэхийг Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар)-д зөвшөөрсүгэй.

8. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/605 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР